

“УГСААТНЫ БИЙ” БИЕЛЭГЭЭНИЙ СУРГАЛТЫН ХААЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Соёлын биет бус өв, өвөг дээдсээс уламжлагдан ирсэн ардын бий биелгээний арга барил, биелэх онцлог, зан үйлийн боловсрол олгох хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, танин мэдүүлэх, орон нутагт бий биелгээг хөгжүүлж түгээн дэлгэрүүлэх зорилгоор "УГСААТАН БИЙ" төслийг УИХ-ын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, ЭЗШУ-ны доктор Б.Баттөмөрийн дэмжлэгээр аймгийн Соёл, урлагийн газар эрхлэн зохион байгуулсан юм.

2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 08 хүртэл үргэлжилсэн 15 хоногийн биелгээний сургалт Мэргэжлийн анги болон сонирхогчийн ангиар 15 хоногийн турш тасралтгүй хичээллсэн Шавь сургалтад анх 140 гаруй хүн бүртгүүлсэн бол сургалтын төгсгөлд 72 суралцагч төгслөө. Үүнээс 16 сургагч багш шалгарч, үлдсэн суралцагчид анхан шатны сургалтад амжилттай хамрагдсан батламжийн эзэд болсон юм. Тус сургалтад хамгийн бага нь 5 настай хоёр суралцагч байсан бол 70 аас дээш насны хоёр ахмад настан байлаа.

Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх энэхүү ажлыг "Монголын язгуур урлагийг өвлөн уламжлагчдын нэгдсэн холбоо" НҮТББ-ын тэргүүн, Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн өвлөн уламжлагч, хамгийн олон шавь сургасан, соёлын биет бус өвийн шилдэг өвлөн уламжлагч МУУГЗ Гэндэнгийн Баяртай багш удирдан зохион байгуулсан юм.

Бий биелгээ нь олон угсаатны бүлгүүдийн хэл, түүх, уламжлал, заншил, дуу хөгжим, үлгэр, домог, туульс, хувцас өмсгөл, тоглоом наадам зэргийг өргөн утга агуулгаар нь өөртөө цогцлоон багтааж уламжилдаг, тэдний амьдрал, үйл ажиллагааны өвөрмөц ахуй байдал, ёс заншил, уламжлал, сэтгэлгээний онцлогийг биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх бүжгийн урлаг юм гэдгийг тэрээр тайлан тоглолтын үеэр онцлон тэмдэглэж байлаа.

Уламжлалт бүжгийн урлаг бий биелгээг 2009 онд Арабын Нэгдсэн Эмират улсын Абу-Даби хотод зохион байгуулагдсан ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн Засгийн газар хоорондын хорооны IV хурлаар ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэн тунхагласан юм.

Энэ сарын 08-ны өдөр Угсаатан бий төслийн сургалт өндөрлөж суралцагчид тайлан биелэгээг Залуучууд театрын их танхимд зохион байгууллаа.

Тайлан биелэгээнд аймгийн ЗДТГ-ын дарга О.Хүрэлчулуун, аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн дарга П.Баярсайхан, аймгийн Соёл, урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ, УИХ-ын гишүүн Б.Баттөмөрийн бие төлөөлөгч Х.Отгонбаяр нарын аймгийн удирдлагууд оролцож баяр хүргэн батламж, дурсгалын зүйлсийг гардуулан өглөө.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
БЭСЖЕХ-НЫ ДАРГА
ЭЗШУ-НЫ ДОКТОР Б.БАТТӨМӨР

ДАРЖАН-УУЛ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

“УГСААТАН БИЙ”

ТӨСӨЛ

СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ
СОНИРХОГЧДОД ЗОРИУЛСАН БИЙ БИЕЛГЭЭНИЙ СУРГАЛТ
2023.03.24-04.06
/15 хоног/

БАГШ
МУУГЗ Гэндэнгийн Баяртай

“Соёлын биег бус өвч”-ийг ур чадварын өндөр түвшинд өгөсөн өвчин уламжлалч
“Соёлын биег бус өвч”ийг амьдралын өвчин уламжлалч
“Хамгийн олон шавь, сургасан өвчин уламжлалч”

БҮРТГЭЛ: Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар 7037-0011, 98393046
ИНЧЭЭЛЭХ БАЙР: Хуучин Дархан Срос клубын байр
ИНЧЭЭЛЭХ ХУВАА: Мэргэжлийн анги: 10.00, 13.00
Сонирхогчийн анги: 14.00-16.00





ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР